

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2012 оны 4 дүгээр сарын 30

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2012 оны 4 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

/тоогоор/					
№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2011-03 сар	Нэмэгдсэн	Хасагдсан	2011-04 сар
1	Даатгалын компани	18			18
2	Даатгалын компанийн салбар	188			188
3	Даатгалын төлөөлөгч	2078	3 ¹	12 ²	2069
4	Даатгалын зуучлагч	10	1 ³		11
5	Даатгалын хохирол үнэлэгч	9			9
6	Актуарч	15			15
7	Бусад	13	2 ⁴		15

Тайлант үед даатгалын компани, даатгалын компанийн салбарын тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹ Хорооны 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 61 дүгээр тушаалаар “Соёмбо даатгал” ХХК-ийн 3 иргэнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгов.

² Хорооны 2012 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 86 дугаар тушаалаар “Миг даатгал” ХХК-ийн 12 иргэний даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

³ Хорооны 2012 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 112 дугаар тогтоолоор “Гэрэлт Буян Ундрах” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

4. Хорооны 2012 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор “Мандал женерал даатгал” ХХК, Хорооны 2012 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 115 дугаар тогтоолоор “Ган зам даатгал” ХХК-иудад тус тус жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон байна.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2012 оны 04 дүгээр сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2011 оны 04 дүгээр сарынхтай харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2011-ИҮ	2012-ИҮ
	Даатгалын нийт хураамж	4,877,111,610.6	6,923,169,988.75
	Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал		1,663,122,937.30
	Олгосон нөхөн төлбөр	642,082,553.4	1,077,535,965.42
	Үүнээс Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр		116,838,567.00
	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо		269.00
	Давхар даатгалд төлсөн хураамж	930,089,657.9	711,955,961.81
	Байгуулсан даатгалын гэрээний тоо	15,222.0	38,829.00
	Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо		30,541.00
	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо		33,691.00
	Хамгийн өндөр даатгалын үнэлгээтэй гэрээ	27,537,979,471.0	143,020,686,755.8
	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	83,731,000.0	240,088,212.07

2012 оны 4 дүгээр сарын байдлаар компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 2046.0 сая төгрөгөөр, олгосон даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеийнхээс 435.4 сая төгрөгөөр тус тус өсч, давхар даатгалд төлсөн хураамж өмнөх оны мөн үеийнхээс 218.2 сая төгрөгөөр буурчээ.

2012 оны 4 дүгээр сард “Хаш хаан даатгал” ХХК шинээр даатгалын гэрээ байгуулаагүй, даатгалын хураамжийн орлого болон даатгалын нөхөн төлбөргүй ажилласан байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

№	Үзүүлэлт	2011-ИҮ	2012-ИҮ
1	Даатгалын нийт хураамж	31,225,796.8	68,695,331.96
2	Олгосон нийт нөхөн төлбөр	6,008,084.0	7,020,812.00
3	Давхар даатгалд төлсөн хураамж		2,781,700.39
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	30	17
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд	12	2
	-Байгууллагын хугацаат даатгалд	2	4
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д	2	0

	- Эмнэлгийн мөнгөний даатгалд	6	3
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	5	4
	-Тэтгэврийн даатгалд	3	0
	-Орон сууцны даатгалд		2
	-Хуримтлалын даатгалд		2
	-Зээлдэгчийн амь насны даатгалд		
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	30,000,000.0	20,000,000.00
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	508,640.0	0

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2012 оны 4 дүгээр сарын үзүүлэлтийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад даатгалын хураамжийн орлого 37.5 сая төгрөгөөр, давхар даатгалын хураамж 2.7 сая төгрөгөөр тус тус өсч, даатгалын нөхөн төлбөр 1.0 сая төгрөгөөр буурч хамгийн өндөр үнэлгээтэй гэрээ нь 20.0 сая төгрөг, хамгийн их нөхөн төлбөрийн үзүүлэлтийг гаргаагүй байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

		/төгрөгөөр/		
№	Үзүүлэлт	2011-4 сар	2012-4 сар	Өсөлт бууралт
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	33,494,569.7	55 923 549.38	22 428 980.00
2	Даатгалын зуучлагчийн орлого	11,945,725.9	26 529 672.55	14 583 946.65
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	81	158	77
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	1,000,000,000.0	1,000,000,000.0	

2012 оны 4 дүгээр сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 22.4 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна. Даатгалын зуучлагч компаниудаас хамгийн өндөр дүнтэй буюу 1.0 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 24.8 сая төгрөгийн хураамж бүхий даатгалын гэрээг “Ачит ундарга” ХХК зуучлан борлуулсан байна.

Тайлант хугацаанд “Асимон брокерс” ХХК даатгалын зуучлалын орлого олоогүй байна. “Ренессанс групп” ХХК, “Эм жи ай би” ХХК, “Монголиан интернэшнл брокерс” ХХК, нь 04 дүгээр сарын мэдээ ирүүлээгүй болно.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

		/төгрөгөөр/		
№	Үзүүлэлт	2011-04 сар	2012- 04 сар	Өөрчлөлт
1	Даатгалын хохирол үнэлсэний орлого	3,901,790.9	6,218,664.00	2 316 874.00

2	Үнэлсэн даатгалын хохирлын тоо	191	377	186
3	Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	69,407,178.0	8 535 000.0	60 872 178.0

2012 оны 4 дүгээр сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 6.2 сая төгрөгийн даатгалын тохиолдлын хохирлыг үнэлж 6.2 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Тайлант хугацаанд “Арвижих эстимэйт” ХХК орлого төвлөрүүлж ажиллаагүй байна. “Итгэлт эстимэйт” ХХК, “Файн эстимэйт” ХХК мэдээ ирүүлээгүй байна.

3. БУСАД

Хорооны 2012 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 93 дугаар тогтоолоор “Мандал генерал” ХХК-ийн дүрмийн санг бууруулж, Хорооны 2012 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 116 дугаар тушаалаар “Монре даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн бүтцэд өөрчлөлт оруулсан байна.

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН МЭДЭЭ

4. ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

Хорооны 2012 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор “Мандал генерал даатгал” ХХК-д, 4 дүгээр сарын 27-ны өдрийн 115 дугаар тогтоолоор “Ган зам даатгал” ХХК-д тус тус жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосноор зөвшөөрөл эзэмшигчдийн тоо 2012 оны 4 дүгээр сарын байдлаар 15 болсныг цагаан толгойн үсгийн дарааллаар доор үзүүлье:

1. “Ард даатгал” ХХК
2. “Бодь даатгал” ХХК
3. “Ган зам даатгал” ХХК
4. “Гэр даатгал” ХХК
5. “Мандал генерал даатгал” ХХК
6. “Миг даатгал” ХХК
7. “Монгол даатгал” ХХК
8. “Моннис даатгал” ХХК
9. “Монре даатгал” ХХК
10. “Мөнх даатгал” ХХК
11. “Номин даатгал” ХХК
12. ”Практикал даатгал” ХХК
13. “Соёмбо даатгал” ХХК
14. “Тэнгэр даатгал” ХХК
15. ”Улаанбаатар хотын даатгал” ХХК

5. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:


2012 оны 4 дүгээр сард даатгалын компаниуд нийт 6,923,169,988.8 төгрөгийн даатгалын хураамж олсноос 1,663,122,937.3 төгрөгийг жолоочийн хариуцлагын албан журмын

даатгалаар, нийт 1,077,535,965.4 төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосноос 116,838,567.0 төгрөгийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар олгосон байна.

Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд буюу 2012 оны эхний 4 сарын байдлаар хийгдсэн жолоочийн даатгалын мэдээг сонирхуулъя:

№	Үзүүлэлт	2012-1 сар	2012-2 сар	2012-3 сар	2012-4 сар	Нийт
1	Даатгалын хураамжийн орлого /төгрөг/	332,507,006.1	512,329,506.4	1,080,618,814.9	1,663,122,937.3	3,588,578,264.7
2	Гэрээний тоо	7,201	9,840	14,869	30,541	62,451
3	Даатгалын нөхөн төлбөр /төгрөг/	11,177,915.0	42,569,350.0	98,942,326.0	116,838,567.0	269,528,158.0
4	Нөхөн төлбөр гаргуулсан даатгуулагчийн тоо	13	99	183	269	564

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагчдын олсон жолоочийн даатгалын хураамж болон олгосон нөхөн төлбөрийн өсөлтийг 2012 оны эхний 4 сарын байдлаар графикаар үзүүлье /сая төгрөгөөр/:



Дээрхээс үзэхэд жолоочийн даатгалтай холбоотой бүхий л үзүүлэлтүүд тогтвортой өссөн байна.

ДААТГАЛЫН ГАЗАР